



ОРХОН АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР



ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 он



ТОВЬЁГ

НЭГ. Тайлант жилд дэвшүүлсэн бодлогын зорилт, стратеги.....	3-5
ХОЁР. Эрхлэх үйл ажиллагааны мэдээлэл.....	6-7
ГУРАВ. Нийгмийн даатгалын сангийн зардлын тайлан.....	7-12
ДӨРӨВ. Хяналт, шалгалт дотоод аудитын үйл ажиллагаа.....	12-19
ТАВ. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт.....	20-23
ЗУРГАА. Санхүүгийн үйл ажиллагаа.....	23-26
ДОЛОО. Цахим үйлчилгээ.....	26-35



НЭГ. ТАЙЛАНТ ЖИЛД ДЭВШҮҮЛСЭН БОДЛОГЫН ЗОРИЛТ, СТРАТЕГИ

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025.09.10-ны өдрийн А/239 тоот тушаалаар тус газрын бүтэц орон тоог шинэчлэн баталсаны дагуу 4 хэлтэстэйгээр төрийн захиргааны албан хаагч 29, төрийн үйлчилгээний албан хаагч-7, нийгмийн даатгалын төлөөлөгч-5 нийт 41 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын болон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Улсын болон Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орхон аймгийн Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр, УИХ, Засгийн газар, аймгийн ИТХ-аас батлан гаргасан үндэсний болон дэд хөтөлбөр, Засгийн газрын болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас батлан гаргасан тогтоол шийдвэр, Гэр бүл хөдөлмөр Нийгмийн хамгааллын яамны болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал шийдвэр, аймгийн Засаг даргын захирамж зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2025 оныг Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласантай холбогдуулан 3 зорилтын хүрээнд 28 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг орон нутагт ханган ажиллахын зэрэгцээ Нийгмийн даатгалын газрын хөгжлийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд түүнд үндэслэн тус газрын Гүйцэтгэлийн төлөвлөгөө баталж доорх зорилгыг төлөвлөн ажилласан. Үүнд:

- ✓ *Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах*
- ✓ *Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын*



сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, гүйцэтгэлийг тайлагнах

- ✓ Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, мэргэжил, арга зүгээр хангах
- ✓ “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх
- ✓ “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах
- ✓ “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах”
- ✓ “Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах
- ✓ Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах
- ✓ Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх”
- ✓ “Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилгыг төлөвлөн ажиллалаа.

Мөн Нийгмийн даатгалын газар Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015, Авлигын эсрэг үйл ажиллагааны менежментийн тогтолцоо ISO 37001:2016 стандартуудын магадлан аудитыг амжилттай хийлгэж, менежментийн бүхий түвшинд сайжруулалтын чиг баримжаатай, төгөлдөршлийн тогтолцооны суурь тавигдаж “Нэгдсэн менежментийн тогтолцоо”-г амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төр засгийн болон аймаг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлтийн холбогдох зорилтыг тайлангийн хугацаанд хэрэгжүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлж чанаржуулах, хөгжлийн бодлогын хурдасгуур бий болгох, нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай, чанарын түвшинг ахиулах зорилгоор доорх бодлого дэвшүүлж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын байгууллагад олон улсын стандартууд нэвтрүүлэх, нийгмийн маркетингийг хөгжүүлэх, нэгдсэн бүртгэлийн систем бий болгох, архивын бүртгэл, хадгалалт хамгаалалтыг автоматжуулах улмаар бүтээмжийг нэмэгдүүлэх, процессын дахин инженерчлэлийг тогтмол хийх замаар мэдээллийн технологи, техникийн дэвшилтэй уялдуулан автоматжуулалт, хиймэл оюун ухаанд суурилсан Цахим засаглалын суурийг тавьснаар Нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээг нэг байцаагчаас шат дамжлагагүй авах боломжийг бүрдүүлж хэвшүүлсэн бөгөөд тухай бүр сайжруулалтыг хийн ажиллаж байна.

Мөн тус газар нь Авлигын эсрэг стандартыг үйл ажиллагаандаа 2022 оноос эхлэн үе шаттайгаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд Авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой нийт 16 сурталчилгааны постер бэлтгэж, нийгмийн даатгалын газрын албаны вэб хуудас болон пэйж хаягт байрлуулан ажиллаж авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулахаас гадна хэлтсийн 75776699 дугаарт залгаж, авлигын талаарх мэдээлэл өгөх, шүгэл үлээх боломжтой болгосон.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын албаны пэйж хуудсанд мэдээ мэдээллийг тогтмол байршуулж Иргэд даатгуулагч, ажилтан албан хаагчдыг авлига, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх олон талд үйл ажиллагааг явуулж байна. Иргэд үйлчилгээ авахаар ирдэг газрын байрны нэг дүгээр давхарт “ТА АВЛИГАГҮЙ БҮСД НЭВТЭРЛЭЭ”, “ТА ӨГӨХГҮЙ-БИ АВАХГҮЙ” , “АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА” гэх мэт самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Мөн авлигын эсрэг стандартын дагалдах журмуудыг боловсруулан баталж газрын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласанаар авлига гарах нөхцөл боломжийг хааж чадсан юм.

ХОЁР. ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, даатгуулагч нарт үзүүлэх үйлчилгээг хуулийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. Иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын байгууллагаас үзүүлэх бүх төрлийн үйлчилгээг олон шат дамжлагагүй нэг дороос шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор үйлчилгээний нэг цэгийг 2018 оноос эхлүүлэн ажилуулж, үйлчилгээний шинэ арга барил, санаачлагыг нэвтрүүлэн, хөгжүүлэн ажиллаж байна. 2025 оны орон нутгийн төсөвт нийгмийн даатгалын ач холбогдлын сурталчилан таниулах, нийгмийн маркетинг хийх гэрээт ажилтаны цалингийн төсөвт санал хүргүүлэн 85 сая төгрөг батлууллаа.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 32 мянган даатгуулагчид нийгмийн даатгалын сангийн үйлчилгээг үзүүлж, 251.8 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж төлбөрийг олгосон байна. 2025 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 189.3 тэрбум төгрөгөөр буюу 86.9 хувиар биелүүлж, 189.3 тэрбум төгрөгийг төв санд төвлөрүүлсэн.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд:

Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах асуудлаар судалгаа хийж, бүртгэлжүүлсэний үндсэн дээр дунд хугацааны хөтөлбөр боловсруулан ажиллаж “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 7.1-д “Ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө”-г жил бүр батлан хэрэгжүүлнэ гэж заасны дагуу оны эхэнд төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулан ажиллаж байна. Албан хаагч, ажилтан бүрт зохих журмын дагуу цалинтай болон цалингүй чөлөө өгч, сурч боловсрох нөхцөл боломжоор ханган дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 2025 онд:

- 7 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгосон
- 22 ахмад настанд 1.050.000 төгрөгийн зардал бүхий хүндэтгэл үзүүлсэн
- 3 албан хаагчийн сургалтын зардалд 1.729.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн
- Нийгмийн даатгалын байцаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийт 10 байцаагчид журамд заасан хувь хэмжээгээр нэмэгдүүлэн сар бүр олгож байна.
- Улсын байцаагчийн шалгалтад тэнцэж эрх авсан 3 байцаагчийн ангилал зэрэглэлийн өөрчлөн ТЗ-7 болгосон.
- ТАТХ-ийн 61.1.1 заасны дагуу 3 албан хаагчид тус бүр 500.000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.
- МУЗГ-ын 83 дугаар тогтоолын дагуу 3 албан хаагчид 24.842.064 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.



- Албан хаагчдын хүүхдүүдийн ая тухтай байдлыг хангах “Хүүхдийн өрөө”-г шинээр тохижуулж ашигласан.

Аймаг орон нутгийн санхүүжилтээр 18 албан хаагчийг Төрийн албаны мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад хамруулсан.

ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

3.1 ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН




Тайлант хугацаанд НДСОТТ-ийн тухай хуулийн хүрээнд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа 17843 тэтгэвэр авагчид, ЦАХТТ-ийн тухай хуулийн хүрээнд 720 тэтгэвэр авагчид нийтдээ 235.1 тэрбум төгрөгийн тэтгэврийг сар бүр хуулийн хугацаанд олгосон.

3.1.1 Шинээр тогтоосон тэтгэвэр

Тайлант хугацаанд 1473 даатгуулагч-иргэнд шинээр тэтгэвэр тогтоосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 906 тэтгэвэр авагчаар буюу 38.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өнгөрсөн онуудад шинээр тогтоох тэтгэврийн тоо тогтворжих хандлагатай байсан бол энэ тайлант үед буурсан байна. Тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа 17.8 мянган тэтгэвэр авагчид нийт 235.1 тэрбум төгрөг олгосон нь батлагдсан төсвийн 100 хувь зарцуулсан байна.

График 1. Шинээр тогтоосон тэтгэвэр



. Шинээр тогтоогдож байгаа тэтгэврийн дундаж дүн өндөр насны тэтгэвэр 1.0 сая төгрөг, ХЧА тэтгэвэр 0.7 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 0.7 сая төгрөг байгаа нь өмнө оны мөн үеэс тус тус 10.2-23.2 хувиар өссөн байна.

3.1.2 Тэтгэвэр авагчийн банк сонголтын мэдээлэл

Шинээр тэтгэвэр тогтоолгосон 1473 иргэн үйлчлүүлэх банкаа өөрийн хүсэлтээр сонгосон ба хуучин тэтгэвэр авч байсан 408 иргэн банкаа сольж нийт 1881 тэтгэвэр авагч үйлчлүүлэх банкаа сонгосон.

Банкны тэтгэвэр барьцаалсан зээлийн нөхцөлтэй уялдуулан иргэдийн банк солих хөдөлгөөн тогтворгүй байна.




График 1. Банкуудаар үйлчлүүлж буй тэтгэвэр авагчийн тоо

Сар бүрийн 25-ны өдрөөр тэтгэврийн дансаа хааж 5 банкттай тооцоо нийлж олголтоо шалгаад дараа сарын файлаа банкуудад бэлтгэн өгч тэтгэврээ олгож байна. Сардаа 18.0 мянган хүнд сард 19.6 тэрбум төгрөгийн тэтгэврийг олгож, 7 хоног бүр хөдөлмөрийн чадвар алдалтын актын сунгалт хийлгэж байгаа болон тэтгэврээ шинээр тогтоолгож байгаа иргэдэд олготыг файл болон жагсаалтаар тухай бүрд нь олгон үйлчилж байна.

3.1.4 Тэтгэврийн даатгалын сангийн зардал

2025 оны тайлант үед аймгийн хэмжээд дундаж тэтгэврийн дүн 1023.17 мянган төгрөг байна. Энэ үзүүлэлт нь өмнө оны дундаж 921.7 мянган төгрөгөөс бага зэрэг буюу 11 хувиар өссөн байна. Баян-өндөр сум, Жаргалант сумуудаас 2026-2027 онуудад тэтгэврийн насанд хүрч байгаа иргэдийн нэгдсэн судалгааг авч нэгтгэхэд ирэх онуудад тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо тогтворжих хандлагатай байна.

Тэтгэврийн төрөл	2024 он		2025 он	
	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/
Өндөр нас	14103	163 173 302,25	15240	196 181 131,61
Хөдөлмөрийн чадвар алдсан	2681	14 448 809,29	1941	15 465 593,40
Тэжээгчээ алдсан	649	5 091 426,93	662	5 774 373,59
Цэргийн	614	11 488 903,90	725	13 183 221,00
Тусгай зохицуулалт	207	116 852,49	240	573 363.12
Нийт	18047	194 319 294,86	18808	230 661 555.72

Хүснэгт 1. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө



3.2 ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН



2025 онд хөдөлмөрийн чадвараа түр алдсан 11585 хүний 4,2 тэр бум төгрөг, жирэмсэн болон амаржсан 1796 хүний 7,8 тэр бум төгрөг, оршуулгын тэтгэмж 488 хүнд 976 сая төгрөг тус тус олгосон байна. Даатгуулагчдаас тэтгэмж авах хүсэлтийг 100% цахимаар хүлээн авсан.

3.2.1 Тэтгэмжийн даатгалын сангийн зардал

Тэтгэмжийн төрөл	2024 он		2025 он	
	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/
ХЧТА-ны	11542	3,504,147.00	11585	4,091,469.40
Жирэмсэн, амаржсан	2058	7,149,205.00	1796	7,777,207.75
Оршуулгын	495	990,000.00	488	976,000.00
Нийт	14095	11,643,352.00	13869	12, 844,677.15

Хүснэгт 2. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

3.3 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САН



Тайлант хугацаанд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 270 тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 4.1 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 87 иргэний тэтгэмжид 167,8 сая төгрөг, хиймэл эрхтэн, протез олгогдоогүй, нөхөн сэргээх зардалд 241 даатгуулагчид 151,3 сая төгрөгийн зардал тус тус зарцуулсан байна.

3.3.1 Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

Зардлын төрөл	2024 он		2025он	
	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/
ХЧА тэтгэвэр	355	4 636 631.00	241	3 814 307.50



ТА-ийн тэтгэвэр	31	361 703.55	29	379 769.96
ХЧТА	53	76,805.00	87	167,805.57
Сувилалын зардал	338	319,653.83	241	151,293.60
Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж	5	10,000.00	4	8 000
Хиймэл эрхтэн, протез	1	1,815.00	-	-
Нийт	783	5 406.608.38	602	4 521 176,63

Хүснэгт 3.Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын үзүүлэлт

3.4 АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН



Шинээр 1196 хүнд ажилгүйдлийн тэтгэмж тогтоож ажилгүйдлийн даатгалын сангаас 4.4 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 180% , тэтгэмжийн дүн 67% -аар өссөн үзүүлэлттэй байна. ААНБ-уудын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор тэтгэмжийн зардал нэмэгдэж батлагдсан төсвийн хуваарийг баримтлан 10-12 сарын 1331 иргэний 2.2 тэрбум төгрөгийн тэтгэмжийг хугацаандаа олгоогүй хүндрэл үүссэн

байна.

3.4.1 Ажилгүйдлийн даатгалын сангийн зардал

Зардлын төрөл	2023он		2024 он		2025 он	
	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/	Хүний тоо	Хөрөнгө /Мян.төг/
Ажилгүйдлийн тэтгэмж	485	2,071,151.05	747	4,896,204.10	1310	5,951,243.87
Сургалтын зардал	-	-	-	-	-	-



Нийт	485	2,071,151.05	747	4,896,204.00	1310	5,951,243.87
------	-----	--------------	-----	--------------	------	--------------

Хүснэгт 4. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын үзүүлэлт

ДӨРӨВ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нэг. Захиргаа, хяналтын хэлтэс

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаалаар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын бүтэц орон тоо, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 28-ны А/31 тоот тушаалаар Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь Захиргаа, хяналтын хэлтэс болж 12 орон тоотойгоор батлагдсанаас Хяналт шалгалтын улсын байцаагч 2, Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч 1 болж нийт 3 хяналтын байцаагч Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байгаад 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын А/32 тоот тушаалаар 11 орон тоотойгоор батлаж 1 орон тоо хасагдан ажиллаж байна.

Захиргаа, хяналтын хэлтсийн 9 албан хаагч, 2 ажилчид нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн комисс, өмч хамгаалах комисс, төсөл хөтөлбөр инновацын бүтээмжийн баг, нэгдсэн стандарт хэрэгжүүлэлтийн баг, эцэг эхийн зөвлөл, маргаан хянан шийдвэрлэх зөвлөл зэрэг газрын дэргэдэх 6 орон тооны бус комисс болон зөвлөлд ажиллаж байна.

Хоёр. Захиргааны ажлын чиглэлээр:

• ХҮНИЙ НӨӨЦИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭЛЭЛ ТАЛААР

2025 оны 12 дугаар сарын байдлаар тус газрын батлагдсан орон тоо 36 байгаагаас гүйцэтгэлээр 35 албан хаагч ажиллаж байна. Газрын даргын орон тоо сул байна. 2025 оны эхний хагаст Төрийн захиргааны албан тушаалын 2 сул орон тоо гарсан бөгөөд Нэг цэгийн үйлчилгээний байцаагч мэргэжилтний сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 27.1.3 дахь хэсэгт заасны дагуу нээлттэй сонгон шалгаруулж төрийн албаны нөөцөд байгаа иргэдээс нөхсөн бол, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний орон тоог Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолын дагуу төрийн өөр байгууллагаас шилжүүлэн авч ажиллуулах журмын дагуу нөхсөн. Орон тооны гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 05-ны өдрийн дотор дээд шатны байгууллагад тайлагнаж ажилласан.

Монгол улсын Их хурлын 2025 оны “Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 48 дугаар тогтоолоор төрийн албаны шинэчлэл хийж, чиг үүргийн давхардалыг арилган төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг цомхон бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх шийдвэр гарсаны дагуу тус газрын орон тоог



4 өөр бууруулж Нэг цэгийн үйлчилгээ цахим мэдээллийн тасгийг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэст нэгтгэж газрын даргын 2025 оны А/32 тоот тушаалаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан. Үүний үндсэн дээр Төрийн жинхэнэ албан хаагчийн орон тоонд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан 3 албан хаагчийг ажлаас чөлөөлж, үндсэн орон тоонд ажиллаж байсан 2 албан хаагчийг төрийн бусад байгууллагад шилжүүлэн ажиллуулах замаар шийдвэрлэсэн. Мөн бүтэц орон тоо шинэчлэгдсэнтэй холбоотойгоор өөр албан тушаалд шилжин ажилласан 5 албан хаагчийн ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газарт хянуулсны үндсэн дээр томилгоо хийж ажилласан.

- **ГАДААД ДОТООД СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЛААР**


Дотоод: 2025 оны жилийн эцсийн байдлаар Байцаагч, ажилтнуудыг чадавхжуулах дотоодын сургалтыг 104 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 1284 албан хаагч хамрагдаж, 267072 хүн*цаг зарцуулан хүний нөөцийн хөгжил, ажилтны мэдлэг ур чадварт онцгой анхаарч ажилласан.

Шинэ ажилтан бэлтгэх сургалтыг 4 удаа төлөвлөгөөний дагуу зохион байгуулж шинээр ажилд орж буй төлөөлөгч байцаагч нарт нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдвэл зохих мэддлэгийг хүргэн ажилласан.

Дотоод сургалтад хамрагдсан албан хаагчдын ирцийн онооны дундаж болон сэдвийн хамаарлыг харьцуулж үзэхэд :

Гадаад: Ажил олгогч, даатгуулагч, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 71 удаагийн сургалтад 3431 иргэд, даатгуулагчийг хамруулсан.





Мөн явуулын үйлчилгээгээр 20 чиглэлд 2 удаа малчдаар явуулын үйлчилгээ хүргэн ажиллаж 678 өрхийн 789 малчин иргэнд мэдээлэл зөвлөгөө хүргэж, 15 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгөөр нийт 544 иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэж ажилласан.

Цахим: Олон нийтэд цахимаар 208 постер, 16 удаагийн шууд нэвтрүүлэг, 45 удаагийн богино хэмжээний бичлэг, рийл, 1 удаагийн контент хийж нийгмийн сүлжээгээр түгээж нийт 1,171,287 хандалтыг авсан байна.

• АЛБАН БИЧИГ ХӨТЛӨЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Албан хэрэг хөтлөлт: Аж ахуй нэгж байгууллага болон дээд шатны байгууллага руу нийт 642 албан бичиг явуулж, аж ахуй нэгж байгууллага болон дээд газраас ирүүлсэн бичгийн тоо 854 ба үүнээс хариутай бичиг 168 бөгөөд 100% бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хаасан байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт: Иргэдээс нийт 332 өргөдөл ирснээс хуулийн хугацаанд 302 өргөдөл буюу 90.9%-ийг бүрэн шийдвэрлэж, 30 өргөдөл буюу 9.1% нь хугацаандаа явж байна. Өргөдөл гомдлын мэдээг сар бүр буюу 11 удаа, тайланг 6 удаа гаргаж хүргүүлсэн.



Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнөөс нийт 20 үүрэг даалгавар өгснийг 100% хэрэгжүүлэн ажилласан.

MNS 5140-1:2021 стандартын 3.2.2-т заасны дагуу ABLE болон E-OFFIC программ дээр ирсэн, явсан албан бичиг, өргөдөл гомдлыг тухай бүрд нь бүртгэн ажиллаж байна.

- **АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

Архивын баримт хүлээн авах: 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/11 тоот дугаартай “Баримт хүлээн авах хуваарь”-ийг газрын даргаар батлуулж хэлтэс, тасаг, нэгжүүдээс хуваарийн дагуу 382 баримтын хамт ирүүлсэн жагсаалтын дагуу архивд хүлээн авч, баримтын бүртгэл хөтөлсөн. Хүлээн авсан баримтуудыг зохих стандартын дагуу цахим мэдээллийн санд бүртгэж, мэдээллийн санг арвижуулсан.

Данс бүртгэл хөтлөх: 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 12 нэр төрлийн 1940 бүртгэл хийсэн.

1. Ажилласан жил нөхөн тооцуулсан иргэдийн бүртгэл - 121
2. Архивын баримт түр ашиглуулсан бүртгэл - 150
3. Архивын хуулбар, хэсэгчилсэн хуулбар, баримтын сэдэвчилсэн жагсаалт олгосон бүртгэл - 367
4. Архивын лавлагаа олгосон бүртгэл (1995 – 2005) - 502
5. 1991-1994 онуудад ажил олгогч байгууллага нийгмийн даатгалын шимтгэл төлж байсан тухай лавлагаа олгосон бүртгэл - 135
6. Албан байгууллагад архивын лавлагаа олгосон бүртгэл - 14
7. Архивд хүлээн авсан баримтын бүртгэл - 29
8. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл (QR кодтой)- 23
9. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл (Хүсэлт явуулсан бичиг) – 302
10. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааны бүртгэл (Хүсэлт ирүүлсэн бичиг) - 149
11. Эрхийн харьцаа дуусгавар болсон тэтгэврийн хувийн хэргээс материал авсан бүртгэл – 52
12. Архивын байрны дулаан, чийгшил болон цэвэрлэгээ хөтлөх бүртгэл – 96

Нийгмийн даатгалын архивын лавлагаа олгох үйлчилгээ:



2025 онд дараах 7 нэр төрлийн нийт 1246 лавлагаа гаргаж иргэн даатгуулагч, байгууллагуудад үйлчилгээ үзүүлж ажилласан бөгөөд нийт лавлагааны 40,2% нь дотоодын 1995-2005 оны лавлагаа эзэлж байна.



Бусад аймаг, дүүрэгтэй цахимаар лавлагаа солилцох:

Архив албан хэрэг хөтлөлтийн “Абле” системээр 451 лавлагааг аймаг, дүүргийн хэлтсүүдтэй солилцсон байна.

- ✓ Бусад аймаг дүүрэг рүү 302 лавлагаа захиалан авсан
- ✓ Бусад аймаг, дүүргээс 149 лавлагаа ирсэн

Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах ажлын талаар:

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын 1 сервер, 41 компьютер, 30 принтер, 12 сканер 19 утасны аппаратын хэвийн ажиллах нөхцөлийг хангаж, шинээр ирсэн 10 компьютер 8



принтер, 2 сканер, 5 таблетийг шаардлагатай албан хаагчид программуудыг суулган бэлтгэн өгсөн. 45 удаа техникийн бүрэн бүтэн байдалд хяналтыг тавьж аюулгүй байдлыг хангаж, 38 албан хаагчийн 11 программ хангамжийн эрхийн тохиргоог зөв хийж, программ болон компьютерын нууц үгийг 1 удаа солиулж ажилласан. Шаардлагатай тохиолдол гарч 12 удаа компьютер болон программын нууц үгийг сольсон. Нийт тэтгэвэр авагчийн тэтгэврийн эх файлын 12 удаагийн олголт, шинээр тогтоогдсон болон сунгагдсан тэтгэврийн 101 удаагийн олголтын файлыг хугацаанд нь илгээж хүлээлцэх актыг хэвлэн архивлаж ажилласан.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан цахим хуудсанд нээлттэй мэдээлэл байршуулах НДЕГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу байгууллагын веб сайт болон мэдээллийн самбарт байршуулах 48 нэр төрлийн мэдээллийг тогтмол шинэчлэн, хөтөлж Shilen.gov.mn сайтад нээлттэй мэдээллээ байршуулан 3-р улиралд 99.36%-тай үнэлгээ авсан. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас <https://e-mongolia.mn/> -д өөрийн байгууллагын мэдээллээ оруулан 4-р улирлыг дүгнүүлэхэд бэлтгэн ажиллаж байна. 2025 оны 8-р сард calltext үйлчилгээг нэвтрүүлэн эхмк-ын хуралд оролцсон иргэд, аж ахуй нэгж байгууллага, сайн дурын даатгалд хамрагдсан иргэдэд сануулах, анхааруулах мессэж 1853 дугаарт илгээсэн байна. Албан бичиг солилцооны дундын систем <https://docx.gov.mn/> -д байгууллын токен үүсгэж абле системд холбож өгсөн.

Гурав. Хяналт шалгалтын ажлын чиглэлээр:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд:

Шинэчлэн найруулсан Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, ахуйн нэгж байгууллага, иргэнээс ирүүлсэн албан тоот, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс ирүүлсэн 41 албан тоот, хүсэлтийг хүлээн авч хуулийн дагуу илэрсэн зөрчлийг арилгаж, хуулийн хугацаанд дараах баримт бичгийг үйлдэж бүрэн шийдвэрлэсэн байна.

- Улсын байцаагчийн акт - 17
- Улсын байцаагчийн дүгнэлтээр цалин залруулга – 16
- Улсын байцаагчийн дүгнэлтээр төрөл залруулга – 16

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд:

12 иргэн, 36 байгууллагад зөрчлийг хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж 8.4 сая төгрөгийн торгуулийг 100% барагдуулж, 350.7 сая төгрөгийн шимтгэл алданги нөхөн төлүүлэхээр



шийдвэрлэж 220.7 сая төгрөгийг төлүүлж 62,9% барагдуулж, 3 байгууллагын өр авлага, алдангид ногдуулсан 166.8 сая төгрөг, 1.5 сая төгрөгийн торгуулийг шүүхэд хандаж шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Гадаад болон дотоод хяналт шалгалтын ажлын хүрээнд:

ГБХНХЯ-аас 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн баталсан 13-07/06 дугаартай удирдамжийн дагуу Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны зарцуулалтыг шалгах ажлын хүрээнд 2762 ажилгүйдлийн хувийн хэргийн бодолт, олголтыг шалгахад 52.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн акт үйлдэж 21.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 18 даатгуулагчид нөхөн олгож, 30.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 28 даатгуулагчид илүү олгосноос 11.3 сая төгрөгийг барагдуулж зөрчлийг арилгах арга хэмжээ авч дөрөвдүгээр улирлын байдлаар 32.9 сая төгрөгийг барагдуулсан нь 63.27%-ийн биелэлттэй байна.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газраас 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн “Аудитаар илэрсэн зөрчлийг шийдвэрлүүлэх тухай” дугаар 360 тооталбан бичгийн дагуу Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшсэн 14 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд үндэслэн сонгуулийн менежер, шадар ухуулагчаар ажиллаж урамшуулал цалин авсан 23 иргэний 12.8 сая төгрөгийн цалингийн сангаас төлөх ёстой 2.4 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлд 0.4 сая төгрөгийн алданги ноогдуулж, Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3-д “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нь нийгмийн даатгалын шимтгэлийг эрх бүхий байгууллагын тогтоосон хугацаанд төлөөгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны дагуу 0.6 сая төгрөгийн торгох шийтгэл оногдуулж, нийт 3.48 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн дансанд бүрэн төлүүлж, нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн санд нөхөн оруулж ажилласан.

Төлөвлөгөөт тусгасан 15 байгууллагаас хуваарийн дагуу 14 объектод хяналт шалгалт хийж, 3 албан шаардлага өгч, 1 байгууллагад зөрчлийн тухай хуулийн дагуу 5.0 сая төгрөгийн торгууль оногдуулан 100% барагдуулж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилласан.

НДЕГ-ын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн баталсан удирдамжийн дагуу Их, дээд болон коллежийн, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн жагсаалтаар ирсэн нийт 6 байгууллагыг бүрэн шалгаж Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж 78.31 сая төгрөгийн цалингийн сангаас 5.87 сая төгрөгийн шимтгэл, 1.90 сая төгрөгийн алданги, нийт 7.78 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж 100%-ийг барагдуулж ажилласан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг, үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн жагсаалтаар ирсэн нийт 6



байгууллагыг бүрэн шалгаж Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж 78.55 сая төгрөгийн цалингийн сангаас 10.15 сая төгрөгийн шимтгэл, 2.58 сая төгрөгийн алданги, нийт 12.74 сая төгрөгийн зөрчлөөс 11.25 сая төгрөгийг буюу 88.3%-ийг барагдуулж ажилласан.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр баталсан урьдчилан сэргийлж, зөвлөн туслах шалгалтын удирдамжийн дагуу гадуур явж 336 байгууллага дээр очиж 444 ажил олгогч, ажилтанд мэдээлэл зөвлөгөө өгч, Нийгмийн даатгалд бүртгүүлээгүй, цалин хөлсөө буруу тайлагнадаг, өр авлага үүсгэсэн зөрчилтэй 46 байгууллагад зөрчил арилгах хугацаатай албан шаардлага өгч ажилласан.

Байгууллагын 48 мэдээллийг веб хуудас, пэйсбүүк хаяг, мэдээллийн 6 самбарт байршуулсан мэдээлэлд улирал бүр хяналт тавьж, дутуу болон шинэчлэх шаардлагатай мэдээллийг залруулж, дараагийн шатны байгууллагаар улирал бүр дүгнүүлэн ажиллаж байна.

байдал:	Үнэлгээ авсан
үнэлгээгээр 96% үнэлүүлсэн.	1-р улирлын
үнэлгээгээр 99% үнэлүүлсэн.	2-р улирлын
улирлын үнэлгээгээр 99% үнэлүүлсэн.	3-р

Шилэн дансны хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдалд улирал бүр хяналт тавьж зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан ба гуравдугаар улирлын байдлаар үйл ажиллагааны шилэн дансны нийт 171 мэдээлэл оруулахаас гуравдугаар улирлын байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 112, хугацаа хоцорсон мэдээлэл 14, мэдээлээгүй 45 байна, Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нийт 159 мэдээлэл оруулахаас гуравдугаар улирлын байдлаар хугацаандаа оруулсан мэдээлэл 107, хугацаа хоцорсон мэдээлэл 10, мэдээлээгүй 42 байна. Шалгалтын явцад сангийн шилэн дансны мэдээллийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээний илүү мэдээлсэн 5 гүйлгээний 8,976.6 сая төгрөгийн мэдээллийг засаж, дутуу мэдээлсэн 12 гүйлгээний 9,168.7.2 сая төгрөгийн гүйлгээг нөхөн байршуулж нийт 17 гүйлгээний 18,145.3 сая төгрөгийн гүйлгээний зөрчлийг арилгасан. Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн нийт 330 мэдээллээс сар, улирал бүр, эхний хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс хуулийн хугацаанд 219 мэдээллийг байршуулсан боловч 24 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнасан. Тухай бүр оруулж байршуулах мэдээллийн шийдвэр гарсан болон орлого зарлагын гүйлгээ хийсний дараа 7 хоногийн дотор байршуулаагүй зэрэг алдаа дутагдлаа дээд газрын болон дотоодын шалгалтын явцад арилгах арга хэмжээ авч ажиллаж байна.

ТАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ**Нэг. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх**

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/320 тоот “Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” тушаалын дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллалаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар:

№	Орлогын задаргаа	Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлтийн хувь
1	Ажил олгогчоос төлөх шимтгэл	118,254,818.60	105,195,932.60	88.96
2	Даатгуулагчаас төлөх шимтгэл	91,998,123.90	78,505,956.27	85.33
3	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны тэтгэмжийн сангаас төлөх	337,939.30	186,319.00	55.13
4	Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны улсын төсвөөс төлөх шимтгэл	273,049.00	279,206.80	102.26
5	Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөн төлөх шимтгэл	62,298.70	166,489.10	267.24
6	Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэл	5,831,524.30	4,034,760.00	69.19
7	ХЧА-ны тэтгэвэр авагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөр	264,554.10	158,710.64	59.99
8	Малчин, туслах малчны улсын төсвөөс төлөх шимтгэл	122,288.70	111,649.50	91.30
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг, эхийн шимтгэл	397,038.70	357,521.40	90.05
10	Бусад орлого	265,275.60	358,284.57	135.06
Дүн		217,806,910.90	189,354,829.88	86.94

Тус онд идэвхтэй үйл ажиллагаа явуулж тайлан ирүүлсэн 1470 аж ахуй нэгж байгууллагын 27093 албан журмын даатгуулагчийн цалин хөлсний сан түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэн ажиллаж НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллаж Нийгмийн даатгалын



санд 2025 жилийн эцсийн байдлаар орлогын төлөвлөгөөг 189.3 тэрбум төгрөгөөр буюу 86.9 хувиар биелүүлж, 189.3 тэрбум төгрөгийг төв санд төвлөрүүлсэн.

Хоёр. Нийгмийн даатгалын хамрагдалт

2025 онд явуулын үйлчилгээг Баян-Өндөр, Жаргалант сумын 10 чиглэлд 2 удаа малчин өрхөөр орж Нийгмийн даатгалын багц хуулийн талаар, Малчны тэтгэврийн тухай, 0-3 настай хүүхэдтэй эхийн сайн дурын даатгал, малчны сайн дурын даатгалын хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээллийг хүргэн тухайн малчны шимтгэл төлж ажилласан жилийн тооцож нийгмийн даатгалын хуулийн мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан. Нийт 678 өрхөөр орж 789 иргэнд мэдээлэл түгээн ажилласан.

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, нийгмийн даатгалын хуулийг сурталчлан таниулах, иргэд, олон нийтэд цаг алдалгүй хүргэх зорилгоор 2025 оны байдлаар “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Орхон аймгийн Баян-өндөр сумын Булаг, Уурхайчин, Найрамдал, Баянбулаг багийн ажлын алба болон Баян-Өндөр сумын ЗДТГазар, Хуульчдын холбоо, Жаргалант сумын ЗДТГазруудтай хамтран зохион байгуулж нийт 15 удаагийн өдөрлөгөөр 544 иргэнд мэдээлэл хүргэсэн байна.

Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэдэд таниулах, соён гэгээрүүлэх, нийгмийн даатгалын талаарх хуулийн мэдлэг олгох зорилгоор 2025 оны жилийн байдлаар байгууллагын ажил олгогч, албан хаагч нарт болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдад, оюутан, сурагчдад 71 удаагийн сургалт хийж 3431 иргэд, даатгуулагчдыг хамруулж мэдээлэл хүргэсэн.

Орхон аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран 2025 оны байдлаар 0-3 насны хүүхэдтэй ээж, 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг эцэг, эхийн судалгааг авч нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор мэдээлэл, зөвлөгөө өгч дуудлага хийн ажилласан байна. Тус ажлын хүрээнд 614 иргэнтэй утсаар холбогдсоноос албан журмаар төлдөг 200 иргэн, сайн дурын даатгал төлдөг 48 иргэн, сайн дурын даатгал төлдөггүй 366 иргэн, 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг 311 иргэнтэй холбогдсон байна. Мөн үсчин, гоо сайхны холбоонд бүртгэлтэй 71 иргэн, ажилгүйдлийн тэтгэмж авсан 420 иргэнд тус тус утсаар мэдээлэл хүргэж ажилласан.

2025 оны гүйцэтгэлээр:

1470 аж ахуй нэгж байгууллагын **27093** албан журмын даатгуулагч хамрагдаж шинээр

✓ **95** аж ахуй нэгж байгууллага хамруулан даатгуулагчийг **266** нэмэгдүүлэн ажилласан байна.

✓ Сайн дурын даатгалд

- Энгийн сайн дурын даатгуулагч – 3276

ШИНЭ 939

- Малчин даатгуулагч – 322 **ШИНЭ 68**

- Тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч

байгаа эх – 398

ШИНЭ 37

- Улсын төсвөөс хариуцан төлж байгаа 0-3 хүртэлх настай хүүхдээ асарч байгаа эх – 324

ШИНЭ 53



- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг эцэг, эх даатгуулагч – 152 **ШИНЭ 33**
даатгуулагчийн гэрээг байгуулан ангиллыг үнэн зөв бүртгэсэн байна.

2025 онд Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас санхүүгийн дэмжлэг авч буй иргэдийг сайн дурын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд 21 даатгуулагчийг хамруулсан ба эдгээр даатгуулагчид санхүүгийн дэмжлэгийн гэрээнд зааснаар 3 жилийн хугацаанд сайн дурын даатгалд хамрууллаа.

Олон нийтэд цахимаар 208 постер, 16 удаагийн шууд нэвтрүүлэг, 45 удаагийн богино хэмжээний бичлэг, рийл, 1 удаагийн контент хийж нийгмийн сүлжээгээр түгээж нийт 1,171,287 хандалтыг авсан байна.

Гурав. Өр авлага барагдуулалт

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагыг барагдуулах ажлын хүрээнд Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” дагуу шат дарааллаар арга хэмжээг авч ажиллаж байна.



Нийгмийн даатгалын шимтгэлийн 100.0 сая төгрөгөөс дээш 271 ба түүнээс дээш хоногийн насжилттай өртэй ажил олгогчийн удирдлагуудад мэргэжил арга зүй, зөвлөн туслах үйлчилгээ

үзүүлэн, Захиргаа хяналтын хэлтэстэй хамтран урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн дагуу төлөвлөгөө хуваарийн дагуу ажил олгогчид хяналт шалгалт хийж 336 ААНБ-ын 444 ажил олгогч, ажилчдад зөвлөгөө мэдээлэл өгч, зөрчилтэй 46 байгууллагад зөрчлөө арилгах албан шаардлага хүргүүлэн биелэлт ханган ажиллалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлрүү шилжсэн 8 тойргийн 13 байгууллагын 14 захирамжийн 855.06 сая төгрөгийн шимтгэлийн авлага, 330.35 сая төгрөгийн алдангид барагдуулалтын явцыг хэлэлцэн 35.17 сая төгрөгийн шимтгэлийн авлага, 6 сая төгрөгийн алданги нийт 41.17 сая төгрөгийн барагдуулалтад тооцоо нийлэн ажилласан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны “Итгэлцлийн аян” ажлыг зохион байгуулах А/244 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах 414 аанб –ын 6,647.872,8 мян төгрөгийн өр авлагаас

- 41 байгууллагатай гэрээ байгуулж 191,801.3 мян төгрөг, сая төгрөг
- 8 байгууллагатай гэрээ сунгаж 252,780.04 мян төгрөг,
- 13 байгууллагын данс гүйлгээг түр зогсоож 132,509.36 мян төгрөг
- 175 байгууллагын хуримтлагдсан авлагаас 875,395.96 мян төг буюу нийт 1,452,486.75 мян төгрөг буюу аяны хүрээнд 21.8 хувь барагдуулан ажилласан байн

ЗУРГАА. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн тайланг улирал бүр гаргаж НДЕГ-ын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт хянуулж баталгаажуулсан. Мөн төсвийн гүйцэтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэгдсэн санхүүгийн тайлангуудыг хагас бүтэн жилээр хуулийн хугацаанд гаргаж, баталгаажсан тайланг сангийн яамны прораммд оруулан ажиллалаа.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газар(хуучин нэрээр Санхүү бүртгэлийн газар)-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 5/841 тоот “Нийгмийн даатгалын сарын мэдээ гаргахад баримтлах чиглэл” албан бичиг, мөн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 07/1310 дугаартай “Төсвийн гүйцэтгэлийн тухай” албан тоотын дагуу дараах мэдээг бэлтгэн ажилласан:

- ✓ 6 банкны 35 дансны орлого, зарлагыг харилцах программд бүртгэж үлдэгдлийг өдөр бүрээр тулган, арилжааны банктай улирал бүр тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулсан;
- ✓ Сангийн мэдээний сан тус бүрийн мөнгөн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдэлийг харилцахын үлдэгдэл мэдээтэй тулган шалгах;



- ✓ Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний төлөвлөгөөг шивж оруулан Сангийн мэдээний бусад орлого зарлагыг мөнгөн гүйлгээний цэвэрлэгээний тайлангийн дүнгээр цэвэрлэн нийт 5 төрлийн мэдээг 6 удаа гаргаж хэмнэлт хэтрэлтийн тайлбарын хамт дараа сарын 02-ны өдөрт багтаан бэлтгэж баталгаажуулан хянуулж ажилласан. Мөн хэлтсийн вэб сайтад мэдээг сар бүр байршуулсан;
- ✓ Байгууллагын урсгал болон үйл ажиллагааны зардлын мэдээг 12 удаа гарган өгсөн;
- ✓ Сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ, тоон мэдээг сар бүрийн эхэнд ЗДТГ-ын Статистикийн хэлтэст хүргүүлэн ажилласан;
- ✓ Шилэн дансны тухай хуулийг баримтлан үйл ажиллагааны 170 (-1), сангийн 159 мэдээг хуулийн хугацаанд оруулж ил тод болгосон. НДЕГ-с төсвийн хуваарь хугацаа хоцорч ирсэн тул 1 мэдээлэл хугацаа хоцорсон төлөвтэй байна.

Нэг. Үйл ажиллагааны зардлын зарцуулалтын талаар

Байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан “Үйл ажиллагааны зардлын 2025 оны төсвийн сарын хуваарь”-ийн дагуу зардлын ангилал тус бүрээр зарцуулан ажилласан байна. Байгууллагын урсгал зардал 1512.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгөө батлагдаж, гүйцэтгэл 1497.9 сая төгрөгийг зарцуулан 14.9 сая төгрөг хэмнэж ажилласан. Аймгийн ЗДТГазраас санхүүжүүлдэг Нийгмийн даатгалын төлөөлөгч хөтөлбөрт 54,8 сая төгрөгийн санхүүжилт авсан ба 5 төлөөлөгчийн цалин хөлсөнд зарцуулан ажиллалаа.

Хоёр. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн талаар

Сангийн 2 нягтлан бодогч банкуудын харилцах дансны гүйлгээг дараа өдөр нь сан тус бүрээр тулган сангийн нэгдсэн программд мэдээллийг үнэн зөв бүртгэж ажилласан. Мөн гүйлгээний утга тодорхойгүй 1211 гүйлгээг тухай бүр залруулан ажилласан байна.

Сангийн орлого зарлагын гүйлгээний бичилт тоо /6 банкны 35 данс/

№	Сан/Банк	Хаан	Капитрон	Голомт	ХХБ	Төрийн сан	Төрийн банк	Нийт гүйлгээ
1	Төвлөрсөн	44857	872	2347	3052	3485	3278	57891
2	Тэтгэврийн	2018	598	799	758	0	1084	5257
3	Тэтгэмжийн	3278	6630	18	12	0	40	9978



4	ҮОМШӨ	228	201	104	300	0	207	1040
5	Ажилгүйдлийн	4198	314	0	0	0	11	4523
Нийт гүйлгээний тоо		54579	8615	3268	4122	3485	4620	78689

Гурав.Сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

2025 оны 12 сарын 10-ны байдлаар 1469 ажил олгогч байгууллагын 173,9 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлогыг санд төвлөрүүлж өмнөх оноос 6.0 хувиар давуулан биелүүлж орлогын төлөвлөгөө 98.7% биелэлттэй байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар шимтгэлийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	143660.5	138896.8	4763.7	96.6%
2	Тэтгэмжийн даатгалын сан	12722.2	14706.4	-1984.2	115.5%
3	ҮОМШӨ даатгалын сан	12480.3	12310.4	169.9	98.6%
4	Ажилгүйдлийн даатгалын сан	5004.0	5413.3	-409.3	108.2%
Дүн		173867	171326.9	2540.1	98.5%

Дөрөв.Сангийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

Сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг анхан шатны баримтыг үндэслэн хугацаанд нь тооцон олгож иргэд даатгуулагчдад хөнгөн шуурхай үйлчилж ирсэн.

Зардалын гүйцэтгэлийг сан тус бүрээр гарган дүгнэхэд /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
---	----------	------------	-----------	-------	------



1	Тэтгэврийн даатгалын сан	191808.1	230851.4	- 39043.3	120.3%
2	Тэтгэмжийн даатгалын сан	10435.6	11344.5	-908.9	108.07%
3	ҮОМШӨ даатгалын сан	5792.6	4552.8	1239.8	78.6%
4	Ажилгүйдлийн даатгалын сан	4521.8	4822.8	-301	106.6%
Дүн		212558.1	251571,5	-39013.4	118.3%

Тав.Сангийн төвлөрүүлэлт, санхүүжилт

2025 оны 12 сарын 10-ний өдрийн байдлаар 202.9 тэрбум төгрөгийн орлого цуглуулж НДЕГ-ын төв санд төвлөрүүлсэн байна.

НДЕГ-аас авсан санхүүжилт:

- ✓ Тэтгэврийн даатгалын санд – 216.9 тэрбум
- ✓ Тэтгэмжийн даатгалын санд – 11.4 тэрбум
- ✓ ҮОМШӨ даатгалын санд – 5.7 тэрбум
- ✓ Ажилгүйдлийн даатгалын санд – 4.8 тэрбум төгрөг нийт 238.8 тэрбум төгрөгийг санхүүжилтээр авсан байна.

ДОЛОО. НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Орхон аймгийн нийт иргэд, даатгуулагч нарт нийгмийн даатгалын анхан шатны бүх үйлчилгээг бүтэн жилийн байдлаар давхардсан тоогоор 22389 даатгуулагчид хүргэж ажилласан. Тухайн иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалд даатгуулахын ач тус, хэрхэн үр шимийн хүртэх, нийгмийн даатгалын тухай хууль болон бусад хууль, тогтоол, шийдвэр, журмын үндэслэлийг тайлбарлан ойлгуулж, иргэний хүсэлтээр сайн дурын гэрээ байгуулах, гэрээ сунгах мөн тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүссэн эсэх талаар зөвлөгөө мэдээлэл хүргэн, материалын иж бүрдэл бүрэн хангасан, эрх үүсэж байгаа материалыг хүлээн авч тэтгэвэр, тэтгэмжийн байцаагчид шилжүүлэн, ажилласан.

Тэтгэвэр: 1209



Тэтгэвэр тогтоолгохоор ирсэн иргэдийн ажилласан жилтэй холбоотой материалыг шалган, бүрдлийг гүйцээн хуулийн дагуу эрх үүссэн баримтыг сканердан сикос праграммд бүртгэн тэтгэврийн байцаагчид 1209 тэтгэврийн материалыг бүртгэл хөтлөн шилжүүлсэн.

Тэтгэвэртэй холбоотой өргөдөл: 906

Тэтгэвэр тогтоолгосон хугацаанаас хойш ажилласан жилийн нэмэгдэл хийлгэх, тэтгэвэр авагч банк солих, тэтгэврийн төрөл өөрчлөх, гэр бүлийн гишүүнд 20 хувь нэмж олгох зэрэг бусад тэтгэвэртэй холбоотой нийт 906 өргөдлийн бүрдлийг гүйцээн баримтыг сканердан сикос праграммд бүртгэн тэтгэврийн байцаагчид шилжүүлсэн.

Ажилгүйдлийн тэтгэмж: 679

Ажлаасаа чөлөөлөгдөж ирсэн иргэдийн ажилласан жилтэй холбоотой материалыг шалган, бүрдлийг гүйцээн хуулийн дагуу эрх үүссэн баримтыг сканердан сикос праграммд бүртгэн тэтгэмжийн байцаагчид 679 тэтгэмжийн материалыг бүртгэл хөтлөн шилжүүлсэн.

Оршуулгын тэтгэмж: 508

Нас барагчийн ажилласан жилтэй холбоотой материалыг шалган, бүрдлийг гүйцээн, тэтгэвэр авдаг бол программаас бүрдлийг гүйцээн хуулийн дагуу эрх үүссэн баримтыг сканердан сикос праграммд бүртгэн 508 нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмжийг тогтоон олгосон.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй тодорхойлолт: 235


Орхон аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт тухайн иргэний ажилласан жилийг тооцож, хуульд заасан ажилласан хугацааг хангаагүй тохиолдолд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй тодорхойлолтыг 235 иргэнд гаргаж өгсөн.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүссэн тодорхойлолт: 23

Орхон аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас тэтгэвэр авч байгаа иргэний ажилласан жилийг тооцож, хуульд заасан ажилласан хугацааг хангасан тохиолдолд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүссэн тодорхойлолтыг албан тоотоор 23 иргэнд гаргаж өгсөн.

Сайн дурын даатгал: 1989

Сайн дурын даатгалын гэрээ шинээр байгуулах болон гэрээ сунгахдаа шимтгэл төлөх орлогоо өөрчлөн, гэрээ байгуулсан зэрэг нийт 1989 материалыг шалган, бүрдлийг гүйцээн, баримтыг сканердан сикос праграммд бүртгэн сайн дурын даатгалын гэрээ үүсгэж байцаагч гарын үсэг зурж тамга дарж нөгөө талаас даатгуулагчаар гарын үсэг зураалан баталгаажуулж ажилласан бол 2024 оны сайн дурын даатгалын гэрээг архивын баримт болгон үдэж 30 боть баримт архивын байцаагчид хүлээлгэн өгч ажилласан.



Цахим хуудас, (CallPro) утасны дуудлага


Чатбот-оор хүргэсэн үйлчилгээ

Нийгмийн даатгалын газрын фэйсбүүк пэйж хуудасны чатбот-оор дамжуулан нийт 855 хэрэглэгчид давхардсан тоогоор 1286 чат бот хариу иргэд, даатгуулагчдад мэдээлэл зөвлөгөө өгсөн. Байгууллагын чатбот-оор дамжуулан тухайн иргэний үйлчилгээ авахад шаардагдах нийт 157 бичиг баримтыг цахимаар хүлээн авч хариуцсан байцаагчид хүргэн ажилласан.

Утсаар хүргэсэн зөвлөгөө

Даатгуулагч иргэдэд өдөр тутамдаа Callpro үйлчилгээ буюу утсаар мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээг 75776699 лавлах утсанд иргэдээс ирсэн нийт 9438 /давхардсан тоогоор/ дуудлага ирснээс 8170 дуудлагад шууд хариу өгч 1268 дуудлага алдсан байна. Нийт алдагдсан дуудлагад эргэн холбогдож, шаардлагатай мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Лавлах утсанд ирсэн дуудлагыг тог тасрах нэгэн зэрэг олон дуудлага ирэх зэрэг тохиолдолд дуудлага алдах тохиолдол гардаг. Энэ тохиолдолд алдсан дуудлага бүрд эргэж холбогддог. Хэрэв дуудлага аваагүй тохиолдолд хариуцсан байцаагчдын хувийн дугаарт шууд холбогдож иргэдэд чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж байна





Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа

Судалгааны зорилго: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

Сэтгэл ханамж: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

Судалгааны аргачлал: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

Судалгааны баримтлах зарчим

- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх




- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

Мэдээлэл цуглуулалт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын Нэг цэгийн үйлчилгээний тасагт иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.

СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:



Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 2025 оны хагас жилийн байдлаар 354 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 206 иргэн буюу 58.2% эмэгтэй, 148 иргэн буюу 41.8% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


График1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:



иргэн буюу 7.9% , 30-39 насны 76 иргэн буюу 21.5%, 40-49 насны 72 иргэн буюу 20.3% , 50-59 насны 119 иргэн буюу 33.6%, 60-аас дээш 54 иргэн буюу 15.3% тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.

Зураг2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл:

Үйлчилгээний төрөл



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 354 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 126 иргэн буюу 35.6%, тэтгэмж 72 иргэн буюу 20.3%, сайн дурын даатгал 50 иргэн буюу 14.1%, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 34 иргэн буюу 9.6%, бусад үйлчилгээ 38 иргэн буюу 10.7%, зөвлөгөө мэдээлэл 34 иргэн буюу 9.6% тус бүр авсан байна.


Зураг3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар:



Дүгнэлт: 2025 оны хагас жилийн байдлаар судалгаанд оролцсон нийт 354 иргэдийн 200 иргэн буюу 56.5%-н маш сайн үнэлгээг өгсөн, сайн үнэлгээг 130 иргэн буюу 36.7%, дунд үнэлгээг 23 иргэн буюу 6.5%, муу үнэлгээг 1 иргэн буюу 0.3%, маш муу үнэлгээг өгөөгүй байна.


Зураг4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээллээ бүрэн авсан байдал:

Мэдээллээ бүрэн авч чадсан уу?




Дүгнэлт: Судалгаанд оролцсон 354 иргэнээс “Тийм” гэсэн үнэлгээг 339 иргэн буюу 95.8% “Үгүй” үнэлгээг 15 иргэн буюу 4.2% өгсөн байна.

Зураг5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ:




Зураг6:Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал /Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц,худалдан авах ажиллагаа./




Дүгнэлт: Судалгаанд оролцсон 354 иргэдийн Тийм үнэлгээг 232 иргэн буюу (65.6%), Үгүй үнэлгээг 20 иргэн буюу (5.6%), Мэдэхгүй үнэлгээг 102 иргэн буюу (28.8%) тус бүр үнэлсэн байна.

Зураг7: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ авсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 354 иргэдийн “Тийм” үнэлгээг 44 иргэн буюу 12.4%, “Үгүй” үнэлгээг 310 иргэн буюу 87.6% тус бүр үнэлсэн байна.

Зураг8: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу?



Дүгнэлт: 2025 оны хагас жилийн байдлаар судалгаанд оролцсон нийт 354 иргэд, даатгуулагчаас “Тийм” үнэлгээг 28 иргэн буюу 7.9%, “Үгүй” үнэлгээг 326 иргэн буюу 92.1% тус бүр үнэлсэн байна.

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР